*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ДОТООД АУДИТ БОЛОН ШИЛЭН ДАНСНЫ ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН П.БАТЖАРГАЛЫН **2025** ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт-ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Нэг: "*Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллага, тусгай сангийн санхүү, үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийх, эрсдэлийн удирдлагаар хангах*" зорилтын хүрээнд: | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. Хөдөлмөр эрхлэлт, Хөдөлмөрийн харилцаа, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан агентлаг, их, дунд эрсдэлтэй төсөвт байгууллага, тусгай сангийн үйл ажиллагаа, төсвийн хөрөнгийн зарцуулалт, холбогдох хууль журмын хэрэгжилтэд дотоод аудит хийнэ. | Аудитын төлөвлөгөөний хэрэгжилт /хувь/ | 1 | 50 | ГБХНХ-ын сайдын эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллага, тусгай сангуудын үйл ажиллагаанд дотод аудит, хяналт шалгалт хийх 2025 оны ажлын төлөвлөгөө боловсруулах, эрсдэлийн үнэлгээ хийхэд шаардлагатай байгууллагын эрсдэл, дотоод хяналтын тогтолцооны талаарх асуулга бөглөж, хавсралт хүснэгтийн дагуу мэдээлэл гаргаж ирүүлэх тухай 2025.01.22-ний өдрийн 09/212 дугаар албан бичгийг харьяа агентлаг, төвүүдэд хүргүүлж холбогдох судалгаа, мэдээллийг гаргуулан авсан.<br>Харьяа агентлаг, төвүүдээс дээрх албан бичгийн дагуу гарган ирүүлсэн судалгаа, мэдээллийг боловсруулан ХШҮДАГ-ын 2025 оны дотоод аудитын ажлыг төлөвлөх, эрсдэлийн удирдлагын үндсэн суурийг тодорхойлох үүднээс улсын салбарын дотоод аудитын аргачлалын дагуу салбарын хэмжээний нийт 209 байгууллага, нэгжийг үндсэн 5 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд их эрсдэлтэй-66, дунд эрсдэлтэй-102, бага эрсдэлтэй-41 нэгж байгууллага үнэлэгдсэн. | 2025.01.01<br>2025.06.30<br>. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2025 оны дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөгөөг боловсруулахад энэхүү эрсдэлийн үнэлгээг үндэслэн төлөвлөсөн<br><br>ГБХНХ-ын Сайдын дэргэдэх Дотоод аудитын хорооны 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн № 02 дугаар тогтоолоор “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллага, тусгай сангийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх 2025 оны ажлын төлөвлөгөө”-г батлуулсан.<br><br>ГБХНХ сайдын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/77 тушаалаар баталсан удирдамжийн дагуу Ахмад настны үндэсний төвийн 2023-2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийсэн. | | |
| 2. | Арга хэмжээ 1.2:<br>Нийгмийн халамжийн сангийн үйл ажиллагааны хүртээмж, үйлчилгээний чанарын талаар тандалт судалгаа, дүн шинжилгээ хийх, эрсдэлийг үнэлэх. | Тайлан -1 | | 1 | ГБХНХЯ-ны ТНБД-ын 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/79 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн халамжийн болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн олголтын явц, үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх” ажлын удирдамжийн дагуу Нийгмийн халамжийн сангийн гүйцэтгэл, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ, тандалт судалгаа хийх, эрсдэлийг үнэлэх ажлыг БЗД-ийн ХХҮХ-ийн хэмжээнд хийж гүйцэтгэсэн. | 2025.01.01<br>2025.06.30 | 100 |
| 3. | Арга хэмжээ 1.3:<br>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангаж ажиллаж, харьяа нэгжүүдээс ирүүлсэн тайланг нэгтгэж, улирал бүр Сангийн яаманд хүргүүлэх | Тайлангийн тоо -4 | 2 | 2 | Тайлант хугацаанд ГБХНХЯ-ны Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Төсвийн үйл ажиллагаа, мөн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл, Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл, Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төслийн 2024 оны Шилэн дансны цахим хуудасны хөтлөлт, нэгдсэн систем мэдээлэл байршуулсан байдал, тайлагналтад 2025 оны 01 дүгээр сарын 10-16-ны өдрүүдэд хяналт хийж, дүнг нэгтгэн гаргасан.<br>НДЕГ, ХХҮЕГ, ХГБХХЕГ ХБХХЕГ, ХАБЭМТ, ХНХСҮСИ-ээс харьяа нэгжүүдийн 2024 оны Шилэн | 2025.01.01<br>2025.06.30<br>. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дансны цахим хуудасны хөтлөлт, нэгдсэн систем мэдээлэл байршуулсан байдал, тайлагналт хяналт хийж нэгтгэн ирүүлсэн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн тайлан, мэдээллийг хүлээн авч хянан, нэгтгэх ажлыг 2025 оны 01 дүгээр сарын 18-23-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн.<br>Нэгтгэлийн явцад ХХҮЕГ, ХБХХЕГ зэрэг байгууллагуудаас буруу, дутуу гаргаж ирүүлсэн тайланг буцааж, тайланг дахин гаргуулан авч тайланд нэгтгэсэн.<br>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2024 оны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн, хавсралт хүснэгтийн хамт 2025.01.24-ний өдрийн 09/264 дүгээр албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.<br>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, зөрчил дутагдлыг бууруулах, таслан зогсоох ажлын хүрээнд ГБХНХ-ын сайдын 2025.02.25-ны өдрийн "Шилэн дансны тухай хууль болон холбогдох журмыг хэрэгжүүлж ажиллах тухай" 03 дугаар албан даалгаврыг харьяа байгууллагуудад 2025.02.27-ны өдрийн 09/676 дугаар албан бичгээр, яамны Төрийн захиргааны удирдлагын газар, Эдийн засаг, санхүү, төсөв, хөрөнгө оруулалтын газарт 2025.02.27-ны өдөр "Дотоод албан бичиг"-ээр тус тус хүргүүлсэн.<br>ГБХНХЯ-ны Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Төсвийн үйл ажиллагаа, мөн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл, Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл, Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төслийн 2025 оны 1 дүгээр улирлын Шилэн дансны цахим хуудасны хөтлөлт, нэгдсэн систем мэдээлэл байршуулсан байдал, тайлагналтад 2025 оны 04 дүгээр сарын 10-15-ны өдрүүдэд хяналт хийж, дүнг нэгтгэн гаргасан.<br>НДЕГ, ХХҮЕГ, ХГБХХЕГ ХБХХЕГ, ХАБЭМТ, ХНХСҮСИ-ээс харьяа нэгжүүдийн 2024 оны Шилэн дансны цахим хуудасны хөтлөлт, нэгдсэн систем | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэдээлэл байршуулсан байдал, тайлагналт хяналт хийж нэгтгэн ирүүлсэн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн тайлан, мэдээллийг хүлээн авч хянан, нэгтгэх ажлыг 2025 оны 04 дүгээр сарын 16-23-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн.<br>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн 2025 оны 1 дүгээр улирлын тайланг нэгтгэн, хавсралт хүснэгтийн хамт 2025.04.24-ний өдрийн 09/1326 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлж, хууль, журмын хэрэгжилтийг ханган ажилласан.<br>Мөн ГБХНХЯ, ҮАГ-ын газартай хамтран 2025.05.13-ны өдөр яамны 10 давхрын хурдын зааланд зохион байгуулсан “ГБХНХ-ын салбарын байгууллагууд, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудит, цаашид анхаарах асуудал” сэдэвт сургалтад оролцож “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, цаашид анхаарах асуудал” сэдвээр сургалт зохион байгуулсан. Сургалтад танхимаар 19 байгууллагын 71, цахимаар 97 байгууллагын 442, нийт 116 байгууллагын 513 удирдах болон санхүүгийн ажилтнууд хамрагдсан. | | |
| Хоёр: “Дотоод аудит, бусад хяналт шалгалтын байгууллагаас өгсөн дүгнэлт, зөвлөмж, тогтоосон акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавих” зорилтын хүрээнд: | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1. Дотоод аудитын хорооны болон удирдлагын шийдвэрээр тусгайлсан өгсөн үүрэг даалгавар, дотоод аудитаар өгсөн зөвлөмж, тогтоосон акт, албан шаардлагын хэрэгжилтийг хханган ажиллах. | Хэрэгжилтийн хувь | - | 1 | 1.Үндэсний аудитын газраас Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжид дурдсан зөрчлийн нөхцөл шалтгааныг тогтоож, хяналт-шинжилгээ хийж зөрчлийг давтан гаргахгүй ажиллах талаар онцгой анхаарч, төсвийн сахилга хариуцлагыг нэмэгдүүлэн дотоод аудитын хорооны тогтоолыг бүрэн хэрэгжүүлж ажиллах тухай Дотоод аудитын хорооны 01 дүгээр тогтоолыг 2023 оны 03 дугаар сарын 24 ний өдрийн 09/883 албан бичгээр хүргүүлж хэрэгжилтэд fas.audit.mn системээр хяналт тавьж ажиллаж байна. | 2025.01.01<br>2025.06.30 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | Арга хэмжээ 2.2 Үндэсний аудитын газар бусад хяналт шалгалтын байгууллагын аудит, хяналт шалгалтаар тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах. | Зөвлөмжийн хэрэгжилт /хувь/ | | 1 | Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2025.04.30-ны өдрийн "Аудитын тайлан хүргүүлэх тухай" 1673 дугаар албан бичгээр ирүүлсэн Аудитын тайлан, зөвлөмжийн дагуу "Аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө" яамны ЭЗСТХО-ын газартай хамтран гаргаж, 2025.06.02.-ны өдрийн 1/1812 дугаар албан бичгээр МУЕА-т хүргүүлсэн. | 2025.01.01<br>2025.06.30 | 100 |
| 3. | Арга хэмжээ № 2.3.<br>"Хариуцсан салбарын чиг үүргийн хүрээнд хамаарах агентлаг, төсөвт байгууллагын албан үйл ажиллагаатай холбоотой статистик мэдээ, судалгааны **"цахим сан"** бүрдүүлэх. | Цахим сан-1 | - | 1 | ГБХНХЯ-болон харьяа ХБХХЕГ, ХАБЭМТ, ХНХСҮСИ, БНСУ дахь ХНХ-ын үйлчилгээний төв, НДЕГ, ХХҮЕГ, ХГБХХЕГазар болон харьяа НДГ, ХХҮГ, ХХҮХ, ХГБХГ-уудын шилэн данс хариуцсан ажилтнуудын нэгдсэн судалгааг агентлаг тус бүрээс авч хариуцсан ажилтнуудын бүртгэл, мэдээлэлтэй болсон.<br>Үндэсний аудитын газар болон харьяа аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газраас НДЕГ болон харьяа газар, хэлтэс, төсвүүдэд 2016-2024 онд хийсэн аудит хийсэн байгууллага, аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг он тус бүрээр гаргуулан авч сан бүрдүүлсэн. | 2025.01.01<br>2025.06.30 | 100 |
| 4. | Арга хэмжээ № 2.4.<br>Хариуцсан салбарын чиг - үүргийн хүрээнд мөрдөгдөж буй хууль, эрхзүйн актуудаар **"мэдээллийн сан"** үүсгэж ашиглах. | Цахим сан-1 | - | 1 | Нийгмийн даатгал болон Нийгмийн халамжтай холбоотой хууль, дүрэм, журмыг https://legalinfo.mn/mn болон https://www.mlsp.gov.mn/ системээс татан авч үүсгэсэн, ажилд ашиглаж байна.<br>Дотоод аудит болон Санхүүгийн хяналт шалгалттай холбоотой хууль, эрх зүйн нэгдсэн мэдээллийн сан үүсгэн баяжуулж ажиллаж байна. | 2025.01.01<br>2025.06.30 | 90 |
| Гурав. "Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах" | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ № 3.1. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль | Дотоод аудит, хяналт шалгалтын тайлан, нотлох баримт, тогтоосон акт, албан шаардлагын биелэлтийг архивын нэгж болгоно. | | 1 | Дотоод аудит, хяналт шалгалтын тайлан, нотлох баримт, тогтоосон акт, албан шаардлагын биелэлтийг архивын нэгж болгон бүрдүүлж, 7 дугаар сард байгууллагын архивт хүлээлгэн өгөхөөр бэлэн болгоод байна. | 2025.01.01<br>2025.06.30 | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Холбогдох яам, төрийн байгууллагаас ирүүлсэн албан бичиг, дүрэм, журмын төслийг судлан хариу өгөх, тайлбар танилцуулга бэлтгэн удирдлагад танилцуулсан байна. | | 1 | Холбогдох яам, агентлаг, салбарын харьяа байгууллагаас ирүүлсэн нийт 34 албан бичгийг хүлээн авч судлан хариу өгөх, шийдвэрийн төсөл боловсруулан удирдлагад танилцуулах, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Үүнд.<br>Хариутай -3<br>Хариугүй -31<br>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, хяналт шалгалт, дотоод аудит, эрсдэлийн үнэлгээ хийхтэй холбоотой мэдээлэл, судалгаа ирүүлэх, мэдээ, тайлан хүргүүлэх зэрэг асуудлаар харьяа агентлаг байгууллага, холбогдох төрийн байгууллагуудад нийт 18 албан бичиг, яамны бодлогын газруудад цаг үеийн асуудал, Сайдын албан даалгавартай холбоотой дотоод албан бичиг 5-ийг тус тус боловсруулж хүргүүлсэн.<br>Тайлант хугацаанд нийт 34 албан бичиг хүлээн авсан бөгөөд хариутай 3 албан бичиг байна.<br>Албан бичиг шийдвэрлэлтийн хувь 66.67 хувь, хугацаа хоцроосон 1 албан бичиг байна.<br>-ХНХСҮСИ-ээс ирүүлсэн 2025.01.24-ний өдрийн 31 дүгээр албан бичигтэй танилцан, хариуг 2025.02.24-ний өдрийн 06/616 дугаар албан бичгээр хариуг хүргүүлсэн.<br>-МУЕА-аас 2025.04.30-ны өдрийн “Аудитын тайлан хүргүүлэх тухай” 1673 дугаар албан бичгээр ирүүлсэн Аудитын тайлан, зөвлөмжийн дагуу “Аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” яамны ЭЗСТХО-ын газартай хамтран гаргаж, 2025.06.02.-ны өдрийн 1/1812 дугаар албан бичгээр хариуг хүргүүлсэн.<br>-ҮАГ-аас ирүүлсэн 2025.03.10-ны өдрийн “Судалгаа ирүүлэх тухай” 09/907 дугаар албан бичгийн дагуу ГБХНХЯ болон харьяа агентлаг, төв, газар зэрэг нийт 21 байгууллагын 2023-2024 оны Төрийн хэмнэлтийн тухай хуулийн судалгааг гаргаж нэгтгэн 2025.06.10-ны өдрийн 09/1931 дүгээр албан бичгээр хариуг хүргүүлж, 2 хавсралтыг ҮАГ-ын аудитор П.Норпилийн norpilp@audit.gov.mn цахим хаягаар хүргүүлсэн. | 2025.01.01<br>2025.06.30 | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | |
| | | Ирсэн албан бичиг, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. | | 1 | Тайлант хугацаанд УИХ-ын гишүүн С.Замирагаас ирүүлсэн 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 03/5458 дугаар албан бичиг болон иргэн Х.Бахытбекийн "... Баян-Өлгий аймгийн зарим байгууллагын үйл ажиллагаанд яамнаас хяналт шалгалт хийлгэх агуулгатай" өргөдлийг 2025 оны 06 дугаар сарын 02-нд ХШҮДАГ-т шилжүүлснийг хүлээн авч судлан, газрын удирдлагад танилцуулан 2025 оны 03 дугаар улиралд хяналт шалгалт хийж, дүнг УИХ-ын гишүүнд хүргүүлэх тухай 01/1942 дугаар албан бичгийг хүргүүлээд байна. | 2025.01.01<br>2025.06.30 | 100 |
| 2. | Арга хэмжээ 3.2:<br>Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх. | Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулсан байна. | | 1 | "Аргачлал, загвар батлах тухай" Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын дагуу ТЖАХ-ийн 2025 оны жилийн Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж нэгжийн менежерээр баталгаажуулагдсан. | 2025.01.01<br>2025.02.01 | 100 |
| | | Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үр дүн, биелэлтийг үнэлүүлсэн байна. | | 1 | ТЖАХ-ийн 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, биелэлтийг Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралтын дагуу, эхний хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинтийн үнэлгээг **8** дугаар хавсралтын дагуу гаргаж хүргүүлсэн. | 2025.01.01<br>2025.06.30 | 100 |
| 3. | Арга хэмжээ 3.3: Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх. | Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд гаргаж тайлагнасан байна. /тийм-1, үгүй-0/ | | 1 | 2024 оны ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд буюу 2025 оны 02 дугаар сарын 06-нд ХАСХОМ- ын цахим системд мэдүүлж, Баталгааны хуудсыг яамны ЭБАТ-д хэвлэж өгсөн. Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажилласан болно. | 2025.01.01<br>2025.02.15 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4. | Арга хэмжээ 3.4:<br>Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлд ажиллах. | Хурлын тоо | 6 | Хурлын тоо | 2025 оны эхний хагас жилд НДЕГ-ын дэргэдэх Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн 5 удаагийн хуралд оролцож нийт 57 иргэний өргөдөл гомдлыг хэлэлцэж, 8 иргэний асуудлыг шийдвэрлэж тэтгэвэр, тэтгэмж олгох асуудал шийдэгдсэн, харин 49 иргэнтэй холбоотой салбар зөвлөлүүдээс гаргасан шийдвэрүүдийг үндэслэлтэй байна гэж шийдвэр гаргасан байна. | 2025.01.01<br>2025.06.30 | 100 |
| 5. | Арга хэмжээ № 3.5:<br>Удирдлага, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврыг заасан хугацаанд нь биелүүлж хариу мэдээлж ажиллах. | Хугацаанд нь бүрэн биелүүлэх | | Үүргийн тоо | Газрын даргаас өгсөн үүргийн дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн төсөлтэй танилцаад 3 заалтыг хасах, 2 заалтыг өөрчлөн найруулах санал Хөдөлмөрийн бодлогын газарт 2025-05-08-нд хүргүүлсэн<br>Мөн өгсөн үүрэг даалгаврыг заасан хугацаанд нь биелүүлж, эргэн танилцуулж байна. | 2025.01.01<br>2025.06.30 | 100 |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Харьяа дээд шатны албан тушаалтны өгсөн үүрэг даалгавраар ажиллах:<br>ГБХНХЯ-ны ТНБД-ын 2025-02-25-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/64 дүгээр тушаал | Үүрэг даалгаврын тоо | - | Үүрэг даалгаврыг биелүүлсэн байна | Тайлант хугацаанд ТНБД-ын 2025-02-25-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/64 дүгээр тушаалын дагуу “Монголын СОС хүүхдийн хотхоны нийгэмлэгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажилласан.<br>Ажлын удирдамжид заасны дагуу тус төвд амьдарч буй хүүхдүүдийн “Хүүхдийн мөнгөн тэтгэмж”-д хамрагдсан байдал, мөн хагас болон бүтэн өнчин хүүхдүүдэд тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгосон байдал, тэтгэврийн зарцуулалт зэргийг шалгаж, үнэлгээ дүгнэлт өгсөн.<br>Монголын СОС-ын хүүхдийн хотхоны нийгэмлэгийн Улаанбаатар хотхонд амьдарч буй 18 хүртэлх насны нийт 108 хүүхэд хүүхдийн мөнгөн | 2025.01.01<br>2025.06.30. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тэтгэмжид бүгд хамрагдсан, бүх хүүхдэд хугацаатай хадгаламж нээсэн байна<br>Харин Тус төвд амьдарч буй Т.Нарангэрэл, Т. Одгэрэл нар нь 2020 оны 07 дугаар сард тус төвд ирсэн бөгөөд Тэжээгчээ алдсаны тэтгэврийг тэдний ээж болох М.Өлзийханд нь 2017 оны 3 дугаар сараас 2020 оны 07 дугаар сар хүртэлх хугацаанд авч байсан, БЗД-ийн ХХҮХ-ээс дээрх 2 хүүхдийн тэжээгчээ алдсаны тэтгэврийг 2020 оны 07 дугаар сараас хойш Асрамжийн газарт шилжсэн гэсэн үндэслэлээр зогсоосон, мөн Б.Эгшиглэн, Б.Отгонтуяа нарын тэжээгчээ алдсаны тэтгэврийг ээж болох Д.Оюунжаргал авч байсныг тус асрамжийн төвөөс БЗД-ийн ХХҮХ-т албан бичгээр хандаж мөн сарын 18-аас зогсоолгосон бөгөөд тэжээгчээ алдсаны тэтгэврийг нь 2025.02.17-оос олгож эхэлсэн байна. | | |
| 2. | ҮАГ-ын 2025.03.10-ны өдрийн “Судалгаа ирүүлэх тухай” албан бичгийн биелэлтийг гаргаж хүргүүлэх | | | | ҮАГ-аас ирүүлсэн 2025.03.10-ны өдрийн “Судалгаа ирүүлэх тухай” 09/907 дугаар албан бичгийн дагуу Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн судалгаа авах тухай 2025.03.21-ний өдрийн 09/875 дугаар албан бичгийг харьяа агентлаг, төв, газруудад, дотоод албан бичгийг яамны ЭЗСТХО-ын газарт тус тус хүргүүлсэн.<br>ГБХНХЯ болон харьяа агентлаг, төв, газар зэрэг нийт 21 байгууллагын 2023-2024 оны Төрийн хэмнэлтийн тухай хуулийн судалгааг гаргаж нэгтгэн 2025.06.10-ны өдрийн 09/1931 дүгээр албан бичгээр хариуг хүргүүлж, 2 хавсралтыг ҮАГ-ын аудитор П.Норпилийн norpilp@audit.gov.mn цахим хаягаар хүргүүлсэн. | 2025.01.01<br>2025.06.30 | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| “ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Арга хэмжээ- 1:<br>Удирдлагын академийн Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах. | Суралцаж төгссөн байх.<br>/ тийм-1, үгүй-0/ | - | 1 | 2025 оны сүүлийн хагас жилд гэж төлөвлөсөн тул хугацаа болоогүй байна. | 2025.07.01<br>2025.12.31 | 0 |
| 2. | Арга хэмжээ 2.<br>“Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III”-т Монгол хэлний тухай хуульд зааснаар 2025 оноос төрийн албан хэргийг кирилл болон үндэсний монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид бүх нийтээр монгол бичигт шилжих бэлтгэлийг хангах арга хэмжээний хүрээнд Монгол бичиг бие даан сурах. | Монгол бичгийн дүрэм, бичиж унших дадлагыг үе шаттай эзэмших. Хүмүүн бичиг сонинг захиалан ашигласан байна. | - | Монгол бичгээр алдаагүй зөв бичиж, уншиж сурсан байна. | “Үндэсний бичгээр компьютерт бичих нь" сэдэвт Монгол бичгийн сургалтад 2025.05.13-ны өдрөөс 2025.06.06 хүртэл нийт 16 цаг хамрагдсан. Хичээлийг Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Б.Баяртуяа(Ph.D) удирдан явуулсан болно. | 2025.01.01<br>2025.06.30 | 100 |
| 3. | Арга хэмжээ 3:<br>Дотоод аудит, хяналт шалгалтын чиглэлээр зохион байгуулагдах гадаад, дотоодын сургалтад хамрагдах. | Сангийн яам, Дотоод аудитын институтээс зохион байгуулсан сургалтад хамрагдсан эсэх.<br>/ тийм-1, үгүй-0/ | - | 1 | Сангийн яам болон Баянгол дүүргийн Засаг даргын дэргэдэх дотоод аудитын албанаас 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсан “Дотоод үйл ажиллагааны стандарт, арга зүй” сэдэвт сургалтад хамрагдаж, Дотоод аудитын олон улсын мэргэжлийн практикийн тасралтгүй хөгжил, үндсэн зарчмууд, бусад дотоод аудиторуудын сайн туршлагаас суралцаж мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн. | 2025.01.01<br>2025.06.30 | 100 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Ахлах мэргэжилтэн ................................/ П.БАТЖАРГАЛ / 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо )*

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*8 дугаар хавсралт*

Нийгмийн хамгааллын бодлогын дотоод аудит болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн Пүрэвсүрэн овогтой Батжаргалын 2025 оны эхний хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний хуудас

Байгууллагын нэр: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Нэгжийн нэр: Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| Нэг: "Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллага, тусгай сангийн санхүү, үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийх, эрсдэлийн удирдлагаар хангах" зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт: | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. Хөдөлмөр эрхлэлт, Хөдөлмөрийн харилцаа, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан агентлаг, Их, Дунд эрсдэлтэй төсөвт байгууллага, тусгай сангийн үйл ажиллагаа, төсвийн хөрөнгийн зарцуулалт, холбогдох хууль журмын хэрэгжилтэд дотоод аудит хийх. | 60 | 10 | 70 | 70 |
| 2. | Арга хэмжээ 1.2: Нийгмийн халамжийн сангийн үйл ажиллагааны хүртээмж, үйлчилгээний чанарын талаар тандалт судалгаа, дүн шинжилгээ хийх, эрсдэлийг үнэлэх. | 60 | 10 | 70 | 70 |
| 2. | Арга хэмжээ 1.3 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангаж ажиллаж, харьяа нэгжүүдээс ирүүлсэн тайланг нэгтгэж, улирал бүр Сангийн яаманд хүргүүлэх | 60 | 10 | 70 | 70 |
| Хоёр: "Дотоод аудит, бусад хяналт шалгалтын байгууллагаас өгсөн дүгнэлт, зөвлөмж, тогтоосон акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавих" зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт: | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1. Дотоод аудитын хорооны болон удирдлагын шийдвэрээр тусгайлсан өгсөн үүрэг даалгавар, дотоод аудитаар өгсөн зөвлөмж, тогтоосон акт, албан шаардлагын хэрэгжилтийг хангаж ажиллах. | 60 | 10 | 70 | 70 |
| 2. | Арга хэмжээ 2.2 Үндэсний аудитын газар бусад хяналт шалгалтын байгууллагын аудит, хяналт шалгалтаар тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийн | 60 | 10 | 70 | 70 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах. | | | | |
| 3. | Арга хэмжээ № 2.3. "Хариуцсан салбарын чиг үүргийн хүрээнд хамаарах агентлаг, төсөвт байгууллагын албан үйл ажиллагаатай холбоотой статистик мэдээ, судалгааны "цахим сан" бүрдүүлэх. | 60 | 10 | 70 | 70 |
| 4. | Арга хэмжээ № 2.4. Хариуцсан салбарын чиг үүргийн хүрээнд мөрдөгдөж буй хууль, эрхзүйн актуудаар "мэдээллийн сан" үүсгэж ашиглах. | 60 | 10 | 70 | 70 |
| Дөрөв. "Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах" | | | | | |
| 1. | Арга хэмжээ № 3.1. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль | 60 | 10 | 70 | 70 |
| 2. | Арга хэмжээ 3.2: Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх. | 60 | 10 | 70 | 70 |
| 3. | Арга хэмжээ 3.3: Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх. | 60 | 10 | 70 | 70 |
| 3. | Арга хэмжээ 3.4: Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлд ажиллах. | 60 | 10 | 70 | 70 |
| 4. | Арга хэмжээ № 3.5: Удирдлага, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврыг заасан хугацаанд нь биелүүлж хариу мэдээлж ажиллах. | 60 | 10 | 70 | 70 |
| Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт | | | | | |
| 1. | ГБХНХЯ-ны ТНБД-ын 2025-02-25-ны өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/64 дүгээр тушаал | 60 | 10 | 70 | 70 |
| 2. | ҮАГ-ын 2025.03.10-ны өдрийн "Судалгаа ирүүлэх тухай" албан бичгийн биелэлтийг гаргаж хүргүүлэх | 60 | 10 | 70 | 70 |
| **Дундаж оноо:** | | | | | |

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Арга хэмжээ 1. Удирдлагын академийн Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах. | | 12 | 12 |
| 2. | Арга хэмжээ №2. “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III”-т Монгол хэлний тухай хуульд зааснаар 2025 оноос төрийн албан хэргийг кирилл болон үндэсний монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид бүх нийтээр монгол бичигт шилжих бэлтгэлийг хангах арга хэмжээний хүрээнд Монгол бичиг бие даан сурах. | | 12 | 12 |
| 3. | Арга хэмжээ 3: Дотоод аудит, хяналт шалгалтын чиглэлээр зохион байгуулагдах гадаад, дотоодын сургалтад хамрагдах. | | 12 | 12 |
| **Дундаж оноо** | | | 12 | 12 |

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 5 | |
| 2. | Дүн шинжилгээ хийх | 5 | |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 5 | |
| 4. | Хариуцлагатай байдал | 5 | |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 5 | |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | | |
| 6. | Мэргэжлийн ур чадвар 1. | 7 | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 2. | | |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 3. | | |
| **Дундаж оноо** | | 7 | 5,3 |

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | |
| 1. | Хандлага, ёс зүй | |
| 2. | Багаар ажиллах | |
| 3. | Харилцаа | |
| **Дундаж оноо** | | 7,8 |

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.) (70 хүртэлх оноо)* | 70 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт *(15 хүртэлх оноо)* | 12 |

| | | |
|---|---|---|
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ<br>*( Нэгжийн даргын үнэлгээ ) (7 хүртэлх оноо)* | 5,3 |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ<br>*(Хамт олны үнэлгээ) (8 хүртэлх оноо)* | 7,8. |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт<br>*(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих) (..... оноо)* | |
| **Нийт оноо** =<br>( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | 95.1<br>95.1 |

***Үнэлгээ өгсөн:*** ***Нэгжийн дарга***

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА ................................ /Д.РЕНЧИНДОРЖ/

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

*2025 оны 06 дугаар сарын 13 - ны өдөр.*
*(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Төрийн жинхэнэ албан хаагч:***

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН ................................ /П.БАТЖАРГАЛ/

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

*2025 оны 06 дугаар сарын 13 - ны өдөр.*
*(огноо)*

***Үнэлгээг хянасан:***

*Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:*

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ ................................ /В.ТҮВШИНЖАРГАЛ/

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

*2025 оны 06 дугаар сарын 20 -ны өдөр.*
*(огноо)*

*Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:*

ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ ................................ Б_БАЯНЖАРГАЛ/

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

*2025 оны 06 дугаар сарын 20 - ны өдөр.*
*(огноо)*

***Үнэлгээг баталгаажуулсан:*** ***Төсвийн шууд захирагч***

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА ................................ /Л.МӨНХЗУЛ/

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

*2025 оны 06 дугаар сарын 20 -ны өдөр.*
*(огноо)*

АТА12944 9132155 9024070603